



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

22 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/1447

Улаанбаатар хот

Гомдлын шаардлагын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын " Ажил олгогч, даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан зөрүүг хянан шийдвэрлэх Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэм"-ийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ажил олгогч даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан зөрүүг хянан шийдвэрлэх Гомдлын шаардлагын зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтын дагуу шинэчлэн баталсугай.

2.Гомдлын шаардлагын зөвлөлд ажил олгогч даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан зөрүүг нийгмийн даатгалын тухай багц хууль, холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн хянан шийдвэрлэж, ажил олгогч даатгуулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.


3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2021 оны А/116 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР

Баянгол дүүргийн Засаг даргын
2021 оны .10.. дүгээр сарын 21..-ны өдрийн
А/1447 дугаар захирамжийн хавсралт



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ГОМДЛЫН ШААРДЛАГЫН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:	Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалтын байцаагч
Гишүүд:	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний тасгийн дарга
	Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн Санхүү бүртгэлийн тасгийн дарга
	Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн дарга
	Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалтын байцаагч
	Иргэний төлөөлөл